

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 6 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР
/МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудас
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-8
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл	9-70
	1.Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд <i>/Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	10-29
	2.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд <i>/Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	29-47
	3.Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд <i>/Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	47-57
	4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл <i>/Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг нарын 4 гишүүн 2021.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	57-64
	5.“Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүнд нэр дэвшигчийн хүсэлтийг хүлээн авах товыг сунгах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	64
	6.“Томилгооны сонсголын тов тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	64-68
	7.Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл <i>/Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий/</i>	68
	8. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл <i>/Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий/</i>	68-69
	9. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл <i>/Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий/</i>	69-70

**Монгол Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 6 дугаар сарын 22-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Засгийн газраас Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар Байнгын хорооны хуралдааныг цахим хэлбэрт шилжүүлж, Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Л.Мөнхбаатар, Х.Нямбаатар, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар, Б.Энхбаяр нар “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас, бусад гишүүд MyParliament программ болон цахим хуралдааны программыг ашиглан Байнгын хорооны хуралдаанд цахимаар оролцов.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн цахим хуралдааны программын ирцэд бүртгүүлж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 09 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ш.Адъяаа.

Нэг.Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, Мэдээллийн технологийн газрын дарга Д.Ган-Эрдэнэ нар “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Ж.Амгалан, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, мөн газрын Мэдээллийн технологийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Билэгдэмбэрэл, Цахим хөгжлийн үндэсний хорооны Ажлын албаны дарга С.Тэнгис, Үндэсний дата төвийн захирал М.Баттулга нар цахимаар тус тус оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бат.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Н.Учрал, Н.Алтанхуяг, Л.Мөнхбаатар, Б.Дэлгэрсайхан, Ж.Сүхбаатар нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг нар “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ цахимаар тус тус хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Б.Энхбаяр, Н.Алтанхуяг нар “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Б.Дэлгэрсайхан нар цахимаар тус тус үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

С.Бямбацогт: Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	6
Бүгд:	18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Дэлгэрэнгүй тэмдэглэл

1 дүгээр асуудал. Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулъя.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар хийнэ. Нямбаатар гишүүнийг урья.

Х.Нямбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний мэдээлэл хайх, олж авах эрхийг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг сайжруулах, төрийн үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай буюу цахим хэлбэрээр хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэх, төрийн байгууллага, үйлчилгээ үзүүлэхдээ мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс өөрөөс нь шаарддаг байдлыг халах нь Засгийн газрын үйл ажиллагааны нэг томоохон зорилт байхаар дэвшүүлсэн. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл буюу Нийтийн мэдээллийн тухай хуулийн төслөөр төрөөс нээлттэй байлгах мэдээллийг нэмэгдүүлж байгаа бөгөөд төрийн үйл ажиллагаа, салбаруудын мэдээлэл ил тод, нээлттэй байхаар, иргэний мэдээлэл авах эрх хангагдахаас гадна төрийн үйл ажиллагаанд иргэд, олон нийт хяналт тавих, санал бодлоо илэрхийлэх зэргээр олон нийтийн оролцоо дээшлэхийн сацуу төрийн цахим шилжилт хийхэд чухал ач холбогдолтой болно.

Хуулийн төсөлд дараах зарчмын асуудлыг тусгалаа.

1. Мэдээлэл хариуцагч нь төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд, түүнчлэн хууль гэрээний үндсэн дээр төрийн чиг үүргийг гүйцэтгэж байгаа холбоо, төрийн бус байгууллага, олон нийтийн радио, телевиз, улс төрийн нам байхаар тусгалаа.

2. Мэдээлэл хариуцагчид байгаа буюу нийтийн мэдээллийг нээлттэй, хязгаарлалттай, хаалттай гэж 3 ангиллаа.

Хаалттай мэдээлэл гэж төрийн нууц болон хуулиар хаалттай гэж тогтоосон мэдээллийг, хязгаарлалттай мэдээлэл гэж хандах, ашиглахад хуулиар хязгаарлаж тогтоосон бөгөөд хүн, хуулийн этгээдийн зөвшөөрлийн үндсэн дээр хандаж ашиглаж болох мэдээлэл болон албаны нууцад хамаарах мэдээллийг ойлгохоор тусгаад байна.

3. Төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах, төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналтыг бий болгох, улмаар авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, эдийн засаг, бизнес, иргэдийн эрх чөлөөг хангах зорилгоор төрөөс нээлттэй байлгах мэдээллийг нэмэгдүүллээ. Тухайлбал:

1.тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл

2.мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа оюуны өмчийн эрх

3.хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнчлэн нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл, мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн ашиг, алдагдлын тайлан, удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүн, гишүүд болон гүйцэтгэх удирдлагын овог нэр, өөрийн авч байгаа цалин, урамшууллын дүн, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьд нэгдсэн төсөв болон үндэсний баялгийн санд оруулж байгаа татвар, хөрөнгийн хэмжээ, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хувь хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гарснаас орсон орлогын талаарх мэдээлэл, Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ, барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт, тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт олгосон газар ашиглах гэрчилгээ, байгуулсан гэрээ, газар ашигласны төлбөр төлөлтийн байдал, улс төрийн намын дүрэм, гишүүнчлэл, хөрөнгө, түүнд өгсөн хандив, зүй ёсны монополь давамгайл байдлаар аж ахуй эрхлэгчийн үнийн бүрдлийн талаарх мэдээлэл, хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл, мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн талаарх мэдээлэл, нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл гэх мэт 5 чиглэлийн 67 багц мэдээллийг нэмж тусгасан.

4.төр цугларсан нээлттэй хязгаарлалттай, хаалттай мэдээллийг боловсруулж нээлттэй өгөгдөл бий болгох замаар эдийн засаг, бизнес, судалгаа

шинжилгээг дэмжих, нээлттэй өгөгдлийг төлбөртэй болон төлбөргүйгээр ашиглуулах харилцааг тусгасан.

5 дугаарт, төрийн үйлчилгээ, иргэн, хуулийн этгээдэд хүндрэлгүй хүргэх, төрийн байгууллагууд хоорондоо цахимаар мэдээлэл солилцох, цахим солилцох орчин, боломжийг бүрдүүлэх, нийтийн мэдээллийн дэд бүтцийн талаар буюу үндсэн хур систем болон дэмжих систем, мөн мэдээллийн сангийн талаарх зохицуулалтыг тусгалаа.

6.дэмжих системийн нэг төрлөөр мэдэгдэл хүргэх системийг бий болгож, иргэн, хуулийн этгээдэд хамаарах хязгаарлалттай мэдээлэлд бусад этгээд хандсан бол түүнчлэн төрийн үйлчилгээ авах шаардлага гарсан бол сануулж, мөн татвар төлөлт, торгох шийтгэлийн төлбөр төлөлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, ард нийтийн санал асуулга, сонгуулийн өдрийн тов зэргийн талаарх мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд тус системээр хийгээд бусад боломжит арга хэрэгслээр хүргэж байхаар тусгалаа.

7.төрийн байгууллага, албан тушаалтан албан харилцаандаа цахим шуудан дэмжих систем ашиглаж байхаар тусгалаа.

8.нийтийн мэдээллийн системээс олж авах, солилцох боломжтой мэдээллийг хувь хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, бусад хуульд цаасан суурьтай, хуульд цаасан суурьтай байхаар заагаагүй бол мэдээлэл хариуцагчийн баримт бичгийг үйлдэх, дамжуулах, хүлээн авах, хадгалах, хамгаалах болон ашиглахдаа цахим баримт бичигт суурилахаар, Мөн цахим баримт бичиг, нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх эрх зүйн үндэслэлийг тодорхой болгох зорилгоор түүний баталгаажилт хүчинтэй байдлын талаар тусгалаа. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ нь хүнд сурталтай, цаг хугацаа их зарцуулдаг, чирэгдэлтэй, төрийн бусад байгууллагад байгаа мэдээлэл, баримт бичгийг бүрдүүлж ирэхийг шаардах зэргээр иргэдэд учирч буй хүндрэл, чирэгдлийг бууруулах ач холбогдолтой болно.

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл буюу Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Нямбаатар сайдад баярлалаа.

Гишүүдийг бас ирц танилцуулъя. Мөнхбаатар гишүүн танхимаар хуралд оролцож байна. Пүрэвдорж гишүүн бас танхимаар хуралд оролцож байна. Цахимаар Дамдины Цогтбаатар гишүүн, Ням-Осорын Учрал гишүүд цахимаар хуралдаа ирцдээ орсон байна. Сэргэлэн гишүүн цахимаар оролцож байгаа юм байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг та бүхэнд танилцуулъя.

Барсүрэнгийн Баасандорж Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга оролцож байна. Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн

яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Даваанямын Ган-Эрдэнэ Хууль зүй, дотоод хэргийн яамны Мэдээлэл технологийн газрын дарга энэ хүмүүс танхимаар оролцож байна.

Батцэнгэлийн Болор-Эрдэнэ Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга цахимаар оролцож байгаа юу. Байгаа. Сүхээгийн Тэнгис Цахим хөгжлийн үндэсний хорооны Ажлын албаны дарга цахимаар оролцож байна. Бадамдоржийн Билэгдэмбэрэл Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Мэдээллийн технологийн бодлого зохицуулалтын газрын дарга цахимаар оролцож байна. Мөнхдоржийн Баттулга Үндэсний дата төвийн захирал цахимаар оролцож байна. Жаргалсайханы Амгалан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн цахимаар оролцож байна.

Ийм хүмүүс оролцож байгааг та бүхэндээ бас танилцууллаа.

Одоо төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү.

Танхимаар Сүхбаатар гишүүнээр тасаллаа. Цахимаар Учрал гишүүн.

Энхбаяр гишүүн асуултаа асууя.

Б.Энхбаяр: Баярлалаа. Би Засгийн газраас Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өргөн мэдүүлсэн энэ Мэдээллийн төрийн болон нийтийн болон хувь хүний мэдээллийн хуулийн багц төслүүдийг бол зарчмын хувьд дэмжиж байгаа. Энэ бол цаг үеэ олсон ийм хуулийн төслүүд байгаа. Энэ 2017 онд Бүртгэлийн багц хууль батлагдаад, тэгээд энэ нэлээн олон мэдээллүүдийг нээлттэй болгох хууль бол гарсан. Тэгээд энэ дотор нэг нээлттэй мэдээлэл болгоно гээд гаргачхаад нэг хэрэгжихгүй байгаа. Маш том дата бол юу вэ гэхээр энэ газрын мэдээлэл байгаад байгаа юм. Үндсэндээ нэг сая гаруй иргэд болон хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн мэдээлэл энэ газрын албаныхан оруулахгүй байгаад байгаа юм. Мэдээллийн санд. Миний ойлгож байгаагаар.

Засгийн газар, Хууль зүйн яам бол энэ дээр нэлээн шахаад ажиллаад байдаг. Хууль зүйн яам улсын бүртгэлийн байгууллага бол энэ мэдээллийн бааз үүсгэх. Энэ дээр бол нэлээн манлайлж ажиллаж байгаа. Манлайлж ажиллаж байгаа учраас энэ и-монголиа буюу цахим систем үүсэх энэ дэд бүтцийг бол бий болгоод байгаа юм аа. Тэгээд одоо энэ бүртгэлийн 2 асуулт байх гээд байгаа юм. Энэ газрын мэдээллийг энэ газрын албаныхан яагаад оруулахгүй байна вэ? Энэ хууль хэрэгжүүлэхгүй байгаад байгаа байхгүй юу. 4 жил хууль хэрэгжүүлэхгүй. Тэгээд миний ойлгож байгаагаар бол энэ нэлээн газрын албаны том мафи ханз үсрэх гээд байх шиг байгаа юм. Ил болгохоор. Зарим хүн бол 80 гаруй газар Улаанбаатар хотын А зэрэглэлд авчихсан, тэрийгээ ингээд зарж байдаг энэ том авлигын сүлжээ байгаа байхгүй юу. Тэгээд энэ сүлжээ нь илэрчих гээд байдаг юм уу, дэлбэрчих гээд байдаг юм уу. Оруулахгүй байгаад байх шиг байгаа юм. Янз бүрийн тайлбар тавиад. Тэгээд энэ нь яагаад оруулах ... /минут дуусав/

С.Бямбацогт: Нямбаатар сайд хариулъя. Энэ хуулийн төслийн үзэл баримтлалд хамгийн том тусаж байгаа асуудал бол энэ. Авлига албан тушаалын асуудлаар одоо хамгийн их яригддаг энэ газрын мэдээлэлтэй холбоотой асуудлыг мэдээлэл хариуцагч буюу төр нь ил болгох үүргийг энэ хуульд хуульчилж өгч байгаа юм. Өөрөөр хэлбэл, бүх төрлийн газар эзэмших, ашиглах, өмчлөх эрх

эзэмшиж байгаа хүмүүсийн тэр мэдээллийг нийтэд ил болгож байгаа. Энэ мэдээллийг хэн дуртай хүн нь авч үзэх энэ боломжийг нээлттэй болгож байгаа. Зүгээр энэ улсын бүртгэлийн байгууллага, Газрын харилцаа, геодези зураг зүйн газар, аймаг, нийслэл, сум дүүргийн газрын албад бүгд мэдээллүүдээ шинээр олгож байгаа газар бүртээ дундын мэдээллийн санд мэдээлэл үүсгээд түүнд нь улсын бүртгэлийн дугаар өгөөд нөгөө нэгж талбарын дугаарт нь тохирсон дугаарыг өгөөд газар олголтын ажиллагаа бол яг Энхбаяр гишүүний хэлсэн хуульд заасны дагуу шинэ олголтууд бүгд улсын бүртгэл дээр нээлттэй ил тод болоод явж байгаа.

Өмнөх тэр 1990-ээд оноос хойш олгогдсон бүх газруудын мэдээллийг ил тод болгох талаар ямар ажлууд хийж байгааг Сайнзориг дарга Энхбаяр гишүүн нэмээд хариулаад өг.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хэн хариулах вэ? 4 дүгээр микрофон.

Хууль зүй, дотоод хэргийн яам Баасандорж. Энхбаяр гишүүний асуултад хариулъя.

Одоогоос 3 жилийн өмнө буюу 6 сарын 21-ний өдөр сая яг Энхбаяр гишүүний хэлсэн Бүртгэлийн багц 4 хууль батлагдсан. Энэ хуулиар бол маш том шинэчлэлийг маш олон ололтуудыг бий болгосон байгаа. Энхбаяр гишүүний хэлсэнчлэн. Үүний нэг нь бол газрын хаягийн сан, одоо үл хөдлөхийн хаягийн мэдээллийн сан нээлттэй байна аа гэж хийж өгсөн. Үүний дагуу Засгийн газраас үе шаттайгаар ажлуудыг хийж байгаа.

Мөн тэр хуулийн үргэлжлэл болох яг иргэдэд мэдээлэл авах эрхийн баталгаа болох энэ Нийтийн мэдээллийн тухай хууль дээр сая сайдын хэлсэнчлэн газар эзэмших, ашиглах энэ мэдээллийн сан нээлттэй байна. Ер нь 5 төрлийн 5 чиглэлийн 67 мэдээллийг энэ Нийтийн мэдээллийн тухай хуулиар нээлттэй болгож өгч байгаа.

Ер нь барилгын одоо тэр газрын хаягийн мэдээллийн сан бол Засгийн газрын тухай хуулиар яг Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд байдаг. Гэхдээ улсын бүртгэлийн байгууллага, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар яг энэ системийнхээ хөгжүүлэлтээр үе шаттайгаар хөгжүүлээд ер нь одоо тун ойрмогхон ашиглалтад орох болов уу гэсэн. Ялангуяа энэ хууль батлагдвал өшөө эрчимтэй ажиллах болов уу гэсэн бол төлөвлөлттэй байгаа. Энхбаяр гишүүн ээ. Газрын хаягийн мэдээллийн сан.

С.Бямбацогт: Баярлалаа. Одоо Учрал гишүүн асуулт асууя. Цахимаар.

Н.Учрал: Засгийн газраас энэ 3 хуулийг оруулж ирж байгаад талархалтай байгаа. Цаг үеэ олсон ийм хуулиуд.

Эхний асуулт. Энэ Нийтийн мэдээллийн тухай хууль гэдэг нэршил дээр би бол санал нэгдэхгүй байгаа. Нийтийн мэдээллийн хууль гэж нэрлээд ингээд зохицуулалт хийх гэхээр магадгүй нөгөө нэг цахим орчин дахь мэдээ, мэдээллийг зохицуулах гээд байгаа юм шиг ийм ойлголт төрүүлээд байгаа юм. Уг нь энэ бол төрийн цахим харилцааны буюу цахим засаглалыг хөгжүүлэх төрийн мэдээллүүдийг хоорондоо хэрхэн солилцох вэ? Илүү өгөгдөл хамгаалалттай дата экс ченж хийх хууль гэж ойлгож байгаа. Энэ хууль дээр Цахим хөгжлийн үндэсний

хороо гээд нэг ийм нэг бүтэц нэмэхээр орж ирээд байгаа юм. Ер нь манайх ингээд нэг цахим хөгжил яриад цахим шилжилт хийе гэхээр хүн, орон тоогоо нэмдэг ийм шинэ бүтэц бий болгодог болчихлоо. Сүүлийн үеийн хуулиуд дээр нэг ийм үндэсний зөвлөл байна, үндэсний хороо байна гээд төрийн бүтцэд хийгддэг ажлуудыг ингэж нэг авсан ийм нэг үндэсний хороо гээд шинэ нэр томьёо гараад ирчихсэн. Энэ агентлаг дээр ч гэсэн сая одоо энэ цахим хөгжлийн хороо гээд нэг юм байдаг юм шиг байна. Тэгэхээр энэ Цахим хөгжлийн үндэсний хороо гэдэг юмыг хуульчилж яах гээд байгаа юм бэ. Тэр агентлаг чинь дэргэдээ байгаа бүтэц, тэр нэгжээрээ энэ зарим ажлуудыг хийгээд явна шүү дээ. Тэгэхээр ингэж нэг дахиад нэг шинэ бүтэц бий болгох шаардлага байгаа юм уу. Бас намар бас энэ яамтай болно гэж ярьж байгаа. Тэгээд одоо бас хаана нь Цахим хөгжлийн хороо нь харьяалагдаад, хэн нь үүнийгээ удирдах гээд байгаа юм бэ. Тэгэхээр ийм хороог хуульчлах шаардлага байна уу?

2 дахь асуулт, цахимаар үзүүлэх гэж байгаа энэ и-монголиа гээд энэ платформ хэрэгжээд амжилттай явж байгаа. Энэ бол төрийн хүнд суртлыг бууруулах зорилготой. Гэтэл дахиад энэ хууль дээр 17.1.1дээр бас л нэг мэдээлэл өгөх байна л гэнэ. Цагийн хуваарь. Байранд, байр, машинд хүн ирүүлдэг, иргэд нь цаг аваад гүйдэг нэг нөгөө л нэг чирэгдэл чинь дахиад л явах гээд байгаа юм. Тэгэхээр цааснаасаа цахим больё, ухаалаг больё гэж байгаа мөртөө дахиад нэг бас юун бас нэг мэдээлэл авах төв байгуулах. Элдэв зардал гаргах болчхов оо.

Тэгээд энэ ТҮЦ машинуудынхаа системийг шинэчилье... /минут дуусав/

С.Бямбацогт: Сайнзориг дарга хариулъя. 2 дугаар микрофон.

П.Сайнзориг: Учрал гишүүний асуултад хариулъя аа. Нэршлийн хувьд энэ дээр үндсэндээ төрийн байгууллагуудаас гадна эргээд улс төрийн нам, олон нийтийн радио, телевиз буюу олон нийтийн өмчтэй, одоо ганц байгууллага болох Олон нийтийн радио телевиз. Эргээд төрийн болон орон нутгийн өмчит компани, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой бас компаниудад бас энэ нийтийн мэдээлэгч буюу нийтийн мэдээллийн хариуцагч болж орж ирж байгаа. Тэгэхээр ер нь зүгээр нийтийн алба гэдэг юм уу, энэ чиглэлдээ бас энэ нэр томьёо, бас манай хуульд энэ эрх зүйн тогтолцоонд бас хэрэглэгдээд ирчихсэн байж байгаа. Энэ агуулгаараа төрийн байгууллагаас гадна бусад бас энэ төрийн чиг үүргийг шилжүүлж авсан төрийн бус байгууллага ч гэдэг юм уу эдгээрийн бас харилцаа орж ирж байгаа учраас нийтийн мэдээллийн тухай гээд зохицуулалтыг орж ирж байгаа.

2 дугаарт энэ бол зөвхөн цахим харилцааг дэмжихээс гадна иргэд бас биечлэн мэдээлэл төрөөс яаж авах вэ гэдэг процедурыг бас зохицуулж өгч байгаа. Өөрөөр хэлэх юм бол заавал одоо юу гэдэг юм цахимаар авах биш биечлэн авах бас нэг ийм сонголт байхыг үгүйсгэхгүй. Үүнийг бид нар бас хуулиар бас хааж болохгүй. Ийм учраас 17 дугаар зүйл дээр бас тодорхой биечлэн яаж мэдээллийг авбал яаж зохицуулах вэ гэдэг зүйлийг бол орсон байж байгаа.

Шинэ бүтцийн хувьд бол үндсэндээ цаашдаа бас Засгийн газрын тухай хуульд заасан журмын дагуу яам байгуулагдсан тохиолдолд бол энэ үндэсний хороо бол татан буугдаад явах байх. Өнөөдрийн түвшинд бол энэ хороо ажилладаг. Ерөнхий сайдын дэргэд ажилладаг. Эргээд энэ Засгийн газар болоод холбогдох Улсын Их Хурлаас байгуулагдах байгууллагуудын цахим шилжилттэй холбоотой үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, дэд бүтцийг холбох эргээд энэ

тал талд гарч байгаа энэ үр ашиггүй зардлуудыг нэгтгэж, эдийн засгийн агуулга ач холбогдлыг нь өндөрсгөхөд энэ хорооны чиг үүрэг бас нэлээдгүй байгаа. Тэгээд мэдээж одоо юу гэдэг юм, Засгийн газрын бүтцэд өөрчлөлт ороод шинээр яам байгуулагдах тохиолдолд энэ давхардсан бүтэц бол байх цаашдаа шаардлагагүй ээ гэдэгтэй тантай санал нэг байна аа.

С.Бямбацогт: Учрал гишүүн тодруулъя.

Н.Учрал: Хуулиар хориглож болохгүй юм бол хуулиар бас нээх шаардлага байхгүй л дээ. Наадах чинь Нийтийн мэдээллийн хууль юм бол элдэв тэр цаасаар авах тэр элдэв тэр нийтийг байгуулж байгаагаа заавал үүнийг хуульчлах шаардлага байхгүй шүү дээ. Эргээд өөрсдөө очоод тэр цэгүүдээс үйлчилгээгээ шаардлагатай бол аваад л явна биз. Тэгээд ер нь цахим руу шилжиж л байгаа бол шилжсэн шиг шилжчихвэл зүгээр байна.

2-т тэр Цахим хөгжлийн хороо гэдэг юмаа хуульчилж, тэр агентлагийн дэргэд байгаа нэгжүүд нь хийж байгаа ажлыг давхардуулж байхын оронд наад дата төв гээд байгаа огт хуульгүй байгууллагаа ядаж хуульчилж өгөөч ээ. Тэгэхгүй бол Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан байгууллага төрийн бүх мэдээллийг хадгалж байдаг. Төрийн үйлчилгээг явуулчихсан ийм байдалтай байж шүү дээ. Тэгэхээр тэр дата төвөө ядаж хуульдаа оруулж, тодорхой эрх үүргийг томьёолж өгмөөр байна.

С.Бямбацогт: Ажлын хэсэг Болор-Эрдэнэ дарга хариулъя. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга.

Б.Болор-Эрдэнэ: Сайн байцгаана уу. Энэ өдрийн мэндийг хүргэе. Учрал гишүүний асуултад нэмэлтээр хариулъя гэж бодож байна. Цахим хөгжлийн үндэсний хорооны хувьд 2019 онд байгуулагдсан. Хэрэг эрхлэх газрын даргын хажууд байгуулагдсан ийм хороо байдаг. Энэ хороон дээр бол бүх яамдын Төрийн нарийн бичгийн дарга нар орсон байдаг. Яагаад вэ гэхээр агентлагаас гадуурх, одоо дээд түвшний байгууллага хоорондын төрийн байгууллага хоорондын одоо уялдаа холбоог хангахын тулд байгуулагдсан ийм бүтэц байдаг. Тэгэхээр Цахим хөгжлийн яам байгуулагдсан тохиолдолд бол Сайнзориг дарга хэлсэн. Энэ бүтэц өөрөө байхгүй болох байх гэж бодож байна. Одоогийн байдлаар бол энэ бүтэц нь энэ төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор байгуулагдсан. Ийм бүтэц 2019 оноос хойш явж ирсэн байдаг.

Дата төвийн хувьд бол өнөөдрийн байдлаар хур систем, дан систем, үндэсний цахим шууданг ажиллуулж байгаа. Одоо и-монголиа-ийн гол арын албыг хашиж байгаа ийм байгууллага бүтэц байгаа. Дата төв дээр байгаа энэ ТҮЦ машинуудыг бид нар шинэчлээд и-монголиа дээр орсон үйлчилгээнүүдийг нэмэхээр ажиллаж байна. Тэгэхээр энэ дээр бол ухаалаг гар утасгүй иргэд, хөдөө орон нутаг, хотын захын дүүргүүдээр энэ одоо аптет хийсэн энэ ТҮЦ машиныг бид нар байршуулж өгөхөөр нэмэлтээр одоо хөгжүүлэлтүүд хийгээд явж байгаа гэдэг мэдээллийг өгөх гэсэн юм.

С.Бямбацогт: Баасандорж дарга нэмээд хариулъя. 4 дүгээр микрофон.

Хууль зүй, дотоод хэргийн яам Баасандорж. Учрал гишүүний асуултад нэмж хариулъя.

Сая Болор-Эрдэнэ даргын хэлсэн дээр. Үндэсний дата төвийн тухай сая Учрал гишүүн асуулаа. Яг эрх зүйн орчны талаар тэр дундаа. Үндэсний дата төвийг 2009 оны 183 дугаар тогтоолоор анх байгуулж өгсөн. Үүнээс хойш яг эрх зүйн байдлын хуулиар хууль, эрх зүйн орчинд бол тодорхой нарийвчилсан зохицуулалт бол байхгүй. Засгийн газрын тогтоолоороо өнөөдрийг хүртэл зохицуулж ирсэн.

Харин Улсын бүртгэлийн ерөнхий хууль түрүүн Энхбаяр гишүүний хэлсэн 2018 онд батлагдсан багц 4 хуулиар яг энэ үндэсний дата төвтэй холбоотой анхны гэж хэлж болох зохицуулалтуудыг хийж өгсөн. Жишээ нь тэр цахим мэдээллийн сан гэж юу хэлэх юм, нээлттэй, хаалттай хязгаартай мэдээллийг яах юм, яг төрийн байгууллага хоорондоо мэдээллийг хэрхэн яаж солилцох юм бэ, тэр журмыг Засгийн газар баталж өгөөч ээ гэж гэж хийж өгсөн юм.

Энэ манай Нийтийн мэдээллийн тухай хуулийн 35 дугаар зүйл дээр Учрал гишүүн ээ, яг Үндэсний дата төвийн эрх зүйн байдлыг маш тодорхой тусгаж өгсөн байгаа. Жишээлбэл, Үндэсний дата төв дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ ээ гээд. Үндэсний системээр мэдээлэл солилцох, холболт үүсгэх, үндсэн системд холбогдох хуулийн этгээдийн мэдээллийн системд тавигдах ... /минут дуусав/

С.Бямбацогт: Алтанхуяг гишүүн асуулт асууя.

Н.Алтанхуяг: Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл орж ирж байгаа нь их сайн зүйл л дээ. Би зүгээр концепцын хувьд.

Би нийтийн мэдээлэл дээр ийм практик дээр байгаа бодит зөрчлүүд л үүсчхээд байгаа юм л даа. Нийтийн мэдээлэл дээр бол ингээд мэдээллийг аваачаад 3 ангилчхаж байна л даа. Нээлттэй, хязгаарлалттай, хаалттай төрд байгаа мэдээллийг. Ер нь зүгээр би энэ өмнө нь бас Их Хуралд байсан. Энэ зунаас хойш Их Хуралд орж ирээд нэг юм гайхаад байгаа. Монгол Улсын төсвөөс гаргаж энэ одоо татвар төлөгчдийн мөнгөнөөс гаргаж хийсэн ажлууд яагаад ингээд нууцад хамаараад явчхаад байдаг юм бэ? Тэгэхээр иймэрхүү харилцаагаа яг зохицуулж чадаж байна уу, үгүй юу. Энэ нийтийн. Миний одоо болгоомжлоод байгаа зүйл бол бид нарын гоё ганган хуулиуд гаргаж болно л доо. Яг амьдрал дээрээ тэр байгууллагын нөхөр чинь өөрөө хуулиар би нууцаа тогтоодог хүн гээд ингээд заагаад өгчихсөн учраас өөрсдөө ингээд Монголбанкны байшин хэдээр боссоныг одоо хүртэл надад хэлэхгүй байгаа шүү дээ. Хууль зүйн яамны байшин хэдээр боссоныг Нямбаатар сайд одоо болтол над хэлэхгүй. Энэ Баасандорж чинь худлаа тоо гаргаж өгч байна.

3 тэрбумаар босдог байшин тийм юм байхгүй л дээ. Тэгэхээр ингээд бид нар ард иргэд байтугай Их Хурлын гишүүн нь мэдээлэл авах эрх чөлөөгүй болчихсон л байна л даа. Тэгэхээр та нар маань энэ хуулийг оруулж ирж гаргах гэж байгаа. Өмнө нэг яриад та ийм ийм хууль оруулж ирээд одоо юмыг бүгдийг нь гоё болгоод алаад өгнө гэсэн, үүнийг бол би дэмжиж байна. Гэхдээ амьдрал дээрээ алаад өгөх болов уу, хаагаад хаячих болов уу гэдэг айдас надад болбол байна. Бүтэн 8 сараас хойш л би одоо маш олон бичиг өглөө шүү дээ. Одоо хамгийн сүүлд энэ Баасандорж гэдэг энэ төрийн нарийныг халмаар байна. Би Улсын Их Хурлын чуулган дээр Улсын Их Хурлын гишүүн мэдээлэл нэхэхэд өгнө гэж хэлчхээд ... /минут дуусав/

С.Бямбацогт: Алтанхуяг гишүүн тодруулъя 1 минут.

Н.Алтанхуяг: 12 сард байх аа. 12 сард төсөв мөнгө ярьж байхад би нэг асуудал хөндөөд. Ингэхэд одоо ерөөсөө эрхэм гишүүн танд бол би одоо ингээд л хуулийн дагуу өгнө гэсэн худал. Одоо өнөөдөр 6 сар гарчихсан. Үгүй ээ ийм байхад ямар элэнцгийнх нь одоо энэ нийтийн мэдээлэл ил тод болох гээд. Аягүй гоё хууль баталдаг. Тэгээд амьдрал дээр ингэж хэрэгжүүлдэг. Тэр байтугай сайд, Төрийн нарийн бичгийн даргаас эхлээд хуулиа хэрэгжүүлдэггүй, хамаг юмыг ингээд доороо аваад дарчихдаг, нуучихдаг. Энэ бол хулгай дээрэм л хийсэн байхгүй юу. Тагнуул би одоо энэ байнга асууж байгаа шүү дээ. Тагнуулын байшин хэдээр боссон юм. Хууль зүйн байшин хэдээр боссон юм. Монголбанкны байшин хэдээр боссон юм. Бүх мэдээллийг ингээд хаачхаад байгаа байхгүй юу. Үгүй ээ, Их Хурлын гишүүнээс хаагаад байна шүү дээ. Тэгэхээр та нар маань энэ хууль дээрээ сайн ажиллаарай. Би оруулж ирж байгааг нь бол дэмжиж байгаа шүү дээ. Дотор нь ороод ярихаар зэрэг хэдүүлээ өшөө яг үнэхээр одоо ил тод болгох ийм л хэрэгтэй л байна. Миний хамгийн их харамсаж байгаа юм болбол Монгол Улсын татвар төлөгч ... /минут дуусав/

С.Бямбацогт: Баасандорж дарга хариулъя. Тодорхой мэдээллүүд өгөх ёстой шүү дээ. Яагаад өгөхгүй байгаа юм.

Алтанхуяг гишүүний асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн Баасандорж. Хуулийн төсөлтэй холбоотойгоор хэлсэн саналтай Алтанхуяг гишүүнтэй болбол санал нэг байна аа. Яг өнөөдөр яг энэ төрд байгаа мэдээллийн ямар мэдээлэл нь ер нь нууцад хамаарах юм, ямар нь хаалттай хязгаартайгаар бусдад мэдээллийг өгөх юм гэдэг нь бол яг тодорхой бус байдаг, зохицуулалтгүй байдаг. Яг энэ үүднээсээ Нийтийн мэдээллийн тухай хуулиар 5 чиглэлийн 67 багц мэдээллийг нээлттэй болгож өгч байгаа. Тэр дундаа төрийн бүх байгууллагуудыг үүрэгжүүлээд тэр төрийн байгууллагууд өөрт томилогдсон мэдээллийн өгөгдлийг буюу статистик мэдээллээ бүгдийг нь нээлттэй болгож өгч байгаа. Тодорхой хугацаатайгаар ямар давтамжтайгаар мэдээлэх журмыг нь Засгийн газраас баталж хийх асуудлыг энэ дээр хийж өгч байгаа юм. Жишээ нь, хөдөлмөрийн яам, нийгмийн одоо Эрүүл мэндийн яам, улсын бүртгэлийн байгууллага, цагдаагийн байгууллага гэх юм уу. Одоо цагдаагийн байгууллагад галт зэвсэгтэй холбоотой хэчнээн хүн зөвшөөрөл өгсөн юм, хэчнээн сумыг импортлох тоо, тоо ширхэг нь бол нээлттэй байхаар.

Тэр дундаа нээлттэй байх мэдээлэл дотор бол энэ төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн, хуулийн этгээдийн ашиг алдагдлын тайлан, удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүн, цалин хөлс, урамшуулал мэт мэдээлэл нээлттэй байна. Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт нь нээлттэй байна. Үүнийг Улсын комисс авсан юм уу, үгүй юу. Мөн энэ тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт ашиглах гэрчилгээтэй байгуулсан гэрээ, ашигласны төлбөр төлөлтийн байдал нь нээлттэй байя, гэх мэт ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийг нээлттэй байна гэх мэт 67 багц төрлийн мэдээллүүдийг нээлттэй болгож өгч байгаа. Энэ хуулийн төслөөрөө яг таны саяын хэлсний дагуу.

Алтанхуяг гишүүний чуулган дээр 2020 оны намрын чуулган дээр яг асуудал тавьсан. Энэ хүрээнд би Алтанхуяг гишүүнтэй бол мөн бас яам дээр байхад бас бичиж уулзсан. Яг энэ чиглэлээр Гадаад хэргийн яам, манай яам хоёр яг ажлын хэсэг гаргачихсан, Алтанхуяг гишүүн ээ, үүнийг эцэслэх гээд яг ажиллаж байгаа гадаад паспорттай холбоотой. Хэрвээ Байнгын хороон дээр яг горимынхоо дагуу нууцаар ярих юм бол манай яам болон Гадаад хэргийн яам, улсын бүртгэлийн

байгууллага холбогдох журмын дагуу бүх мэдээллийг 2015 оноос хойш өнөөдрийг хүртэл гадаад паспорттай холбоотой ямар ажлууд явагдсан юм гэдэг ... /минут дуусав/

С.Бямбацогт: Барилгын үнэ асуусан шүү дээ. Тийм ээ. Хууль зүй, дотоод хэргийн яамны барилгын төсөвт өртөг хэд вэ? Тагнуул, Монголбанк гээд яриад байгаа шүү дээ. Бэлдээд хариулчхаарай, хариулт өгчхөөрэй. Мэдээлэл.

Мөнхбаатар гишүүн асуултаа асууя.

Л.Мөнхбаатар: Тодруулга 1 минутаа нэмээд авчихъя. Энэ бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоо бий болгох ажил бол 2009 оноос эхэлсэн. Бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох зорилтыг 25 дахь Ерөнхий сайд Баяр дарга анх дэвшүүлэн тавьсан. Энэ зорилтыг хэрэгжүүлэх үүрэг нь бол тухайн үед тухайн танхимд Тэргүүн шадар сайдаар ажиллаж байсан, Алтанхуяг гишүүн энэ асуудлыг эрхэлж байсан. Засгийн газар талаасаа байгууллагаасаа би одоо хариуцан ажиллаж байлаа. Энд бол амаргүй ажил болсон. Энэ цагаас эхлээд арваад жилийн хугацаанд маш их бүртгэл мэдээллийг цугласан. Үүнийгээ бас хэрэглээнд оруулах чиглэлээр ч гэсэн багагүй ахиц гараад байгаа юм. Тухайлбал тэр хур систем, дан систем, и-монголиа гээд одоо ашиглаж байгаа энэ бүхий л бүртгэл үйлчилгээтэй холбоотой зүйлүүд бол түүнээс улбаатай өнөөдөр ингээд хөгжөөд явж байгаа. Нэгэнт бий болсон энэ эдгээр мэдээллүүдийг цаашид хэрхэн ашиглах вэ, түүний мэдээллийнх нь аюулгүй байдлыг хэрхэн хангах вэ гэдгийг одоо хуульчлах зайлшгүй шаардлага байгаа. Ийм учраас энэ орж ирж байгаа энэ 2 хуулийг бол дэмжиж байгаа юм.

Би яах вэ, тухайн хуулийн төсөл тус бүрд нь бол асуудал саналуудаа бас хэлээд явъя гэж бодож байна. Нийтийн мэдээллийн тухай хууль дээр бол нэг хоёр зүйл харагдаж байна. Тодруулах зүйлүүд байна. Нийтийн мэдээлэл хариуцагч гээд энэ 6 дугаар зүйл дээр байна л даа. Ийм шинэ ойлголт орж ирж байгаа юм байна. Төрийн байгууллага болон төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой, хувийн эрх зүйн хуулийн этгээд гэх мэтээр ийм одоо нийтийн мэдээлэл хариуцагч этгээд гээд заагаад оруулсан байна. Төр гэхээр чинь их явцуураад байна аа. Явцуу харагдаад байна. Эд нар хоёр зүйл орхигдсон юм болов уу гэж би одоо хараад байгаа юм.

1 дүгээрт нь энэ нийтийн мэдээлэл хариуцагч гэдэг утгаараа энэ төрийн бус байгууллагыг оруулах нь зүйтэй. Иргэний хуулиар энэ ашгийн төлөө бус хуулийн этгээд гээд энэ холбоо, сан, хоршоо нийлбэрээр байгуулагддаг шүү дээ. Үүнийг оруулах нь зүйтэй. Яагаад гэхээр эдгээр байгууллагууд олон нийтийн төлөө нийтийн үйл ажиллагаа явуулдаг гэж байна шүү дээ. Тэгээд энэ хэд чинь одоо ажиллагаа нь ил тод байх ёстой юм. Мөн тэр байгууллага нь нийгэмд ямар үйл ажиллагаа явуулах юм, гадаад, дотоодын ямар санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулж байгаагаа тайлагнаж байх ёстой. Энэ агуулгаар төрийн бус байгууллагууд байх ёстой гэж үзэж байгаа юм.

2 дугаарт нь хувьцаат компаниуд нийтийн мэдээлэл эзэмшигч шүү дээ. Хувьцаат компаниуд. Энэ бас ялгаагүй энэ жагсаалтад орох ёстой гэж би хараад байна. Одоо хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй олон компаниуд байна. Эдгээр нт бол өөрсдийнхөө технологи, үр ашгаа сайжруулах гээд хөрөнгө оруулалт хийгээд энэ мэдээллээ хувьцаа эзэмшигчдэдээ тайлан тавьдаг. Энэ агуулгаараа энэ хоёр

субъект бол би орхигдсон байна аа гэж үзэж байна. Энэ 2-ыг оруулж байж бүрэн болох ёстой юм биш үү гэдэг энэ асуултыг тавьж байна.

2 дугаарт нь энэ 7.4 дүгээр зүйлд нь энэ хуульд хаалттай байхаар заасан. Эсвэл төрийн нууцад хамаарах мэдээллийг хаалттай мэдээлэл гэж үзнэ ээ гэсэн байна. Тэгэхээр энэ хуульд хаалттай байхаар заасан гэдэг ийм бүлэг ойлголт гарч ирээд байна л даа. Миний ойлгож байгаагаар болбол энэ хаалттай мэдээлэл гэдэг чинь төрийн нууц, албаны нууц, хувийн нууц байх ёстой. Үүнээс бусад нь бүгд нээлттэй байх ёстой гэж ойлгоод байгаа юм. Гэтэл энэ ийм хаалттай мэдээлэл гэсэн ийм категори гаргаж ирээд энэ дотор бол бөөн мэдээлэл ... /минут дуусав/

С.Бямбацогт: Сайнзориг дарга хариулъя. 3 минут.

П.Сайнзориг: Өмнөх мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар бол зөвхөн төрийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулсан бол энэ удаад төрийн өмчит компаниуд, хууль эсвэл гэрээний үндсэн дээр төрийн чиг үүрэг шилжүүлж авсан төрийн бус байгууллагууд. Одоо жишээ нь Худалдаа үйлдвэрийн танхим, Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо ч гэдэг юм уу. Олон нийтийн радио телевиз. Төрийн эрх мэдлийн төлөө эвлэн нэгдэж бас улс төрийн сонгуульд оролцож байгаа гэдэг утгаараа улс төрийн нам, эдгээрт өгч байгаа хандив, гишүүнчлэлийн мэдээллүүдийг ил тод энэ мэдээлэл хариуцагчаа байхаар ингээд оруулж байгаа юм аа.

Төрийн бус байгууллагуудыг бас зүгээр таны саналуудыг бас анхаарч авч үзье. Ер нь бол тусдаа хуулиар нь зохицуулах бүрэн бололцоотой гэж харж байгаа. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хууль өргөн барьсан. Төрийн бус байгууллагын үйл ажиллагааны тайлан, авч байгаа санхүүжилт, юунд зарцуулав гэдэг мэдээллийг бол ил тод болгох ёстой гэдэг зүйлийг бас олон улсын байгууллагаас ч тавьдаг. Ер нь бид ч гэсэн хуулийн төслөө энэ чиглэлдээ боловсруулж, Засгийн газраас өргөн барьсан байгаа.

Хувьцаат компанийн асуудал бол Үнэт цаасны тухай хууль болоод Компанийн тухай хуулиараа ингээд одоо ч явдаг ийм харилцаа байгаа. Тэгэхээр ерөнхийдөө бусад асуудлууд бол холбогдох хуулиудаар бол бас мэдээллийн ил тод байдлаа хангаж, үйл ажиллагааныхаа тайланг хувьцаа эзэмшигч, гишүүнчлэл болоод олон нийтийн санхүүжүүлэгч этгээдүүдтэй нээлттэй байх ийм зарчмаар цаашдаа явах ёстой. Энэ дээр бол тантай санал нэг байна.

Хаалттай мэдээлэл хуульд хаалттай байхаар заасан мэдээлэл гэдэгт бол төрийн нууц байгаа, дээрээс нь одоо жишээ нь Улсын бүртгэлийн хуулиар бид нар гарын хурууны хээ буюу энэ бие нь давхцахгүй өгөгдөл нь бол хаалттай мэдээлэл байна аа гээд заачихсан. Энэ мэдээллүүдийг цаашдаа ойлгож байгаа.

Албаны нууц болбол хаалттай биш. Энэ бол үндсэндээ хязгаарлалттай мэдээлэл байгаа. Ер нь энэ хуулиуд батлагдсаны дараагаар бас бид төрийн болон албаны нууцын хуулийг бас тодорхой эргэж харахгүй бол байгууллагууд ерөнхийдөө албаны нууц нэрээр маш их мэдээллүүдийг хаалттай горимд оруулж хэрэглээнд оруулахгүй байх, мэдээлэл өгөхгүй байх ийм нөхцөл байдал бол үндсэндээ практик дээр үүсээд байгаа. Бид хэд үүнийг бас дахиад тодорхой судалгаатай хэрэгжилтийн үр дагавар нь үнэлж байж Засгийн газраас бие даасан байдлаар оруулж ирнэ.

С.Бямбацогт: Нямбаатар сайд нь нэмээд хариулъя.

Х.Нямбаатар: Мөнхбаатар гишүүний саяын асуусан тэр Сайнзориг ерөнхийдөө хэлчихлээ дээ. Хуучин мэдээлэл хариуцагч гэдэгт хэнийг хамруулж ойлгож байсан бэ гэвэл зөвхөн төрийг хамааруулж ойлгож байсан. Одоо мэдээлэл хариуцагч гэдэгт төр, төрийн өмчийн оролцоотой компани, хуулийн этгээд, төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа олон нийтийн байгууллагууд бүгд энэ мэдээлэл хариуцагч болж байгаа юм. Мэдээлэл хариуцагчид 3 төрлийн үндсэн мэдээлэл байгаа. Нээлттэй, хаалттай, хязгаартай.

Нээлттэй мэдээллийг ерөөсөө ямар ч тохиолдолд иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байна аа л гэж байгаа юм.

Хязгаартай мэдээллийн тухайд заавал тухайн мэдээллийн эзний зөвшөөрлийн үндсэн дээр авдаг, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх юм уу, бусад хуульд заасан арга хэмжээний дагуу уг мэдээлэлд хууль ёсны дагуу халддаг л болох ёстой. Хэрэв хууль бусаар хэн нэг хүний улсын бүртгэл дэх мэдээлэлд халдсан тохиолдолд тухайн мэдээллийн эзэнд notification хэлбэрээр сэрэмжлүүлэг нь очдог. Таны мэдээлэлд Дорж гэдэг хүн ийм улсын байцаагч үндэслэлгүйгээр халдлаа шүү гэдэг ийм notification мессеж ирдэг. Ийм байдлаар зохицуулалт хийж байгаа.

Зүгээр Мөнхбаатар гишүүний хэлж байгаа шиг нээлттэй компаниудын мэдээлэл, угаасаа нөгөө өөрийнхөө салбарын хуулиудаар хувьцаа эзэмшигчид, мэдээлэл нь нээлттэй байх зохицуулалттай учраас хэт хувийн эрх зүйн субъектын үйл ажиллагаа, ялангуяа компанийн дотоод үйл ажиллагаанд Нийтийн мэдээллийн тухай хуулиар халдах нь өөрөө зохимжгүй ээ гэж үзсэн.

С.Бямбацогт: Одоо Дэлгэрсайхан гишүүн асуулт асууя.

Б.Дэлгэрсайхан: Өнөөдрийн энэ оруулж ирж байгаа хуулийг дэмжиж байна аа. Тэгэхдээ бид энэ хэтэрхий ерөнхий яриад байх юм аа. Сүүлийн үед бол энэ сошиалаар явж байгаа мэдээлэл чинь одоо хувь хүний нууц, нөгөө хүний хувийн амьдрал руу хэтэрхий их ордог болсон. Та нар бүгдээрээ л мэдэж байгаа. Подъездны камер хүртэл хөдөлгөөнтэй болоод л түүнийгээ бусдын энэ олон юуг юм хэвлэл мэдээллийг олж авсан энэ тэр гээд л ийм инээдэмтэй юм их ярьдаг болсон юм. Тэгээд энэ цагдаагийн болон энэ бусад хууль хүчний байгууллагын гүйцэтгэх ажил чинь бүүр хувь хүн хийдэг болсон шүү дээ. Энэ нууц биш болчихсон шүү дээ. Тэгээд үүнийгээ ер нь яаж хязгаарлах юм? Энэ чинь үүнээсээ үүнээсээ тусдаа л байх л даа. Тэгэхээр Хууль зүйн сайд байгаа дээр үүнийг би асууж байгаа юм.

Яах вэ өнөөдөр бид төр барьж байгаа улсуудын хувьд энэ асуудал ингээд ямар нэгэн байдлаар дарагдаад ч юм уу ингээд өнгөрч болно оо. Дараа нь та нарыг өөрсдийг чинь яг ингээд л хянадаг, ухдаг, энд тэнд явж байгаа чинь бүгдийг нь бичдэг, ийм л болж хувирна шүү дээ. Тэгээд одоо энэ Хууль зүйн сайд зарим юманд өөрөө ч гэсэн өртсөн ийм юм гарч л байсан. Тэгээд үүнийгээ яаж шийдэх юм. Ялангуяа бусдыг элдвээр гутаан доромжлох. Энэ хэлж байгаагаа бол одоо бид мэдээлэл хүргэж байна гэж ярьдаг болсон шүү дээ. Тэгээд энэ нь хэвээрээ цаашаа үргэлжлэх юм уу. Сүүлийн үед зарим Их Хурлын гишүүд төрд ажиллаж байгаа, Их Хуралд гишүүн болсон бол доромжлуулж болно. Энэ бол таны бараг хохь шахуу юм яриад байгаа юм. Тэгээд Их Хурлын гишүүн болсон, сайд

болсноороо хүнд доромжлуулах тийм ёстой юм бол тэгээд цаашдаа энэ чинь бид хуультай байгаад яах юм тэгвэл.

С.Бямбацогт: Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Дэлгэрсайхан гишүүний яг саяын ярьж байгаа асуудлыг бид нар дараагийн танилцуулах хуулийн төслөөр зохицуулахаар бас танилцуулга бэлдсэн байгаа. Энэ бол хувь хүний нууцын тухай хууль буюу хувь хүний нууцыг хязгаарлагдмал хүрээнд тогтоож, тэр хувь хүний чөлөөт орон зайг бий болгох, тодорхой орон зай байршлуудад хяналтын камер зоохыг хориглох, түүнтэй холбоотой мэдээллийг задруулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгасан ийм дараагийн хуулийн төслийн танилцуулга байгаа.

Одоо бид нарын хэлэлцэж байгаа бол энэ Нийтийн мэдээллийн тухай хууль. Нийтийн мэдээллийн тухай хуулиар түрүүн үзэл баримтлалыг танилцуулахад би танилцуулсан. Тэр хүрээнд харилцаануудыг зохицуулна аа. Хувь хүний нууцын тухай хуулиар бол саяын Дэлгэрсайхан гишүүний хөндсөн асуудлыг ярих учраас үүнийг дараагийн хуулийн төслийн танилцуулга дээр дэлгэрэнгүй танилцуулъя аа гэж хэлэх гэсэн юм.

С.Бямбацогт: Дэлгэрсайхан гишүүн тодруулъя.

Б.Дэлгэрсайхан: Үгүй ээ, яах вэ, дараа нь орж ирвэл сайд байна. Хууль зүйн яамныхан мэдэж байгаа байх аа. Тэгвэл энэ Улсын Их Хурал одоо энэ зарим мэдээллээ ингээд ер нь бүх л болж байгаа юмаа ингээд илэн далангүй цацаад байдаг энэ юмаа ер нь хэзээ хязгаарлах юм, тэгвэл. Энэ бас Улсын Их Хурлын тусдаа хуулиар явах уу, дэгээр явах уу? Одоо бид нарын чинь энэ Байнгын хороо, дээр нь бусад ярьж байгаа бүх л зүйл нээлттэй яваад, тэгээд энд чинь маш их алдаа оноо гараад гадагшаа задардаг. Ер нь Монгол Улсад мэдээллийн нууц гэж юм ерөөсөө байхаа больсон шүү дээ. Тэгээд үүнийгээ ямар хуулиар зохицуулах юм вэ тэгвэл. Үүнийг нэг хариулж өгөөч. Тэгэхгүй бол сүүлийн үед энэ Их Хурал дээр ч гэсэн зах замбараагаа алдсан шүү дээ. Ярих хөөрөх юм нь улсад нууц гэж ер нь юм байдаг юм уу? Энэ Монгол Улсад чинь, ер нь. Бүх л юм, энэ ардчиллын зарчмаар одоо нээлттэй гэдэг нэрэн дор нуудаг, хаадаг юм байхгүй болсон шүү дээ. Одоо зарим юмаа бол ярьж хэлж чадахаа ч байсан шүү дээ. Ялангуяа ... /минут дуусав/

С.Бямбацогт: Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Төрийн болон албаны нууцын тухай хууль өнөөдөр ч гэсэн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Дэлгэрсайхан гишүүн ээ. Таны хэлж байгаа наад асуудал бол Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг нээлттэй, хаалттай аль хэлбэрээр явуулах вэ гэдгийг энэ хуулиар шийдэх боломжгүй ээ. Энэ бол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар энэ асуудлыг бид нар Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дараа чуулганы дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэх үед бас яригдаж байсан асуудал. Зүгээр улс орнуудын парламентыг харахад яг манайх шиг ийм, одоо бүх талаараа нээлттэй хуралдааны үйл ажиллагаа явдаг ийм парламентын дэгтэй орон бол их цөөхөн юм байна лээ. Жишээлбэл дийлэнх улс орнууд ардчилсан улс орнуудын парламентын чуулганы хуралдаан бол хүн болгоны өмнө о микрофон ярих тийм спикер байдаггүй. Урьдчилж заавал цаг мэдүүлдэг, тэгээд индэрт гарч хэлэх үгээ

хэлдэг, ийм зохицуулалтууд ихтэй явдаг юм байна лээ. Европ чиглэлийн нөгөө сонгодог парламент ... /минут дуусав/

С.Бямбацогт: Сүхбаатар гишүүн асуулт асууя.

Ж.Сүхбаатар: Хэдүүлээ, өнөөдөр болбол юу байж байна аа? Маш чухал хуулийн төслийг хэлэлцэж эхэлж байна. Хууль зүйн байнгын хороо. Би 10 жилийн өмнө Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга байхдаа Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийг анх батлуулж байсан хүн. Яг энэ чиглэлээр хэлэлцүүлэг эд нар хийгээд бүр өөрөө биечилж яваад, харамсалтай нь тэр хуулийг сайн хэрэгжүүлж амжаагүй байхад өмнөх одоо Ерөнхийлөгч байсан Элбэгдорж Ерөнхийлөгч Шилэн дансны хууль гээд популист маягаар ашиглаад тэр хуулийн хаа гуяыг нь салгаж хаяад ингээд явчихсан юм. Тэрийгээ цоо шинэ хууль мэтээр тайлбарлаад. Тэгээд одоо энэ хуулийг яах вэ, өөрчлөх гэж орж ирж байгаа юм байна. Нэрийг нь өөрчилье гэж байгаа юм байна. Агуулгыг нь өөрчилж байгаа юм байна, тодорхой хэмжээнд.

Гэхдээ 1 юм дутуу байна. Хариуцлагын юман дээр. Жишээлбэл 1 чухал зарчим байгаа байхгүй. Нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх гэж. Зарчим болгочихсон байгаа байхгүй юу. Энэ бол зарчмаасаа гадна заалт байхгүй юу. Үүнийг өгөөгүй бол ажлаасаа халагддаг байх хэрэгтэй юу шаардаж байгаа болбол ажлаас нь халдаг байх хэрэгтэй. Тэгэхээр энэ Төрийн албаны хуулиар зохицуулна. Эрүү зөрчлийн хуулиар зохицуулна гэхээр энэ дотор чинь байгаа зарим байгууллагууд чинь Төрийн албаны хуулийн хариуцлагын систем байхгүй. Нэг ийм асуудал байгаа. Үүнийгээ яаж тооцсон юм бэ? Хариуцлага.

2 дугаарт, Монголд мэдээллийн хулгай, мэдээллийг паразитлах явдал болбол манай төрд байгаа хамгийн том эмгэнэл байгаа. Хүний нийтийн энэ мэдээллийн хүрээнд олж авсан мэдээллүүдийг бизнесийн болон хувийн зорилгоор маш их ашиглаж байгаа. Тэгэхээр энэ ардчиллын амин сүнс бол энэ дарангуйлалгүй нийгэм ч гэсэн сүүлийн үед яриад байна. Одоо бид нарыг ч гэсэн болгоомжлоод л ингээд л яриад байгаа. Одоо энэ хууль чинь л одоо амин чухал асуудал шүү дээ. Мэдээлэл, нийтийн мэдээлэл бол иргэдийг хамгийн хүчирхэгжүүлдэг, хамгийн гол зэвсэг хамгаалалт нь энэ хуулийн төсөл. Одоо энэ хуулийн төслийг бид чанарын шинэ шатанд гаргаж чадах юм бол дараачийн бас 2 дахь хууль байгаа. Хувь хүний нууцыг хадгалах, хамгаалах, энэ хоёрыг хийх юм болбол тэр дарангуйлалтай нийгэм чинь бий болохгүй. Тэр ардчилсан дэглэмийг чинь мэдээллийн ... /минут дуусав/

С.Бямбацогт: Сүхбаатар гишүүн 1 минут тодруулъя.

Ж.Сүхбаатар: Тэгэхээр энэ хуулийн талаар бол их олон зүйлийг ярьж хэлж болмоор байгаа юм. Тэгээд би энэ асуух гэж байгаа асуулт бол энэ агуулга дээр чинь нэг юм их явах ёстой шүү. Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийг та нар нэрийг нь сольж байна. Нийтийн мэдээлэл. Энэ зөв байх, паблик информэйшн, паблик дата, эд нар гээд явж байдаг. Тэгэхдээ үүний агуулга нь ингээд жоохон хэлтийгээд байгаа юм нь төрийн байгууллагын илүү талд нь анхаарах гээд байгаа шүү. Мэдээлэл хүлээн авах тэр эрх, эрх чөлөөг нь хангах талд нь илүү анхаарах ёстой шүү. Тэгэхээр энэ дотрын одоо тэр хамгийн баримталж байгаа тэр зарчим дотор та хэд маань хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл ил тод нээлттэй байх гээд тавьчхаж байгаа байхгүй юу. Хамгийн гол

амин сүнс нь юу юм бэ гэхээр мэдээлэл чөлөөтэй хүлээн авах эрх л байгаа юм. Үндэслэлгүй хязгаарлалт тавихгүй байх ёстой гэдэг. Тэгээд энэ талд нь одоо та бүхэн яаж анхаарч байна. Тэгээд түүнээс биш нээлттэй, хязгаарлалттай, хаалттай гээд л. Ингээд л үндсэндээ тийм журамлах маягаар ингээд явчхаж байгаа байхгүй юу. Тэгээд энэ хууль чинь явж явж одоо Монгол ... /минут дуусав/

С.Бямбацогт: Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Сүхбаатар гишүүнтэй санал нэг байна аа. Бид нар энэ нөгөө мэдээлэл хариуцагч гэдэг маань олон төрлийн субъект байгаа учраас хариуцлагын тогтолцоог нь хуулийг хэлэлцэх эсэхийг дэмжээд ажлын хэсэг гараад явахаар бас тал талаас нь ярих зүйлүүд байгаа юм аа. Төрийн албан хаагчид бол Төрийн албаны тухай хуулиар хариуцлага хүлээлгээд, төрийн жинхэнэ албан хаагчид. Бусад нийт эрх зүйн субъектүүдэд Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгээ ээ гэдэг ийм концепцоор явж байгаа. Цаашид бид нар энэ Нийтийн мэдээллийн тухай хуулийн гол агуулга, амин сүнс нь юу вэ гэвэл ерөөсөө энэ ардчилсан нийгэмд хүн мэдээлэл авах эрхээрээ хангагдана аа л гэсэн үг.

Бусдын тэр давуу байдалтай олж авсан тусгай зөвшөөрөл, лиценз, энэ зүйлүүд ямар байдлаар энэ хүнд ирсэн юм бэ гэдэг. Энэ мэдээллүүдээс эхлээд тэр 5 төрлийн 67 багц мэдээллийг энэ хуулиар анх удаа бүр үүрэгжүүлж бүх нийтийн мэдээлэл болгож, нээлттэй мэдээллийн тэр ангилалтад оруулж өгч байгаа юм. Хууль хэлэлцэх явцад бас шаардлагатай бол энэ мэдээллүүдийг хүрээг өргөтгөх ийм боломжууд шаардлагууд байгаа гэж ойлгож байна. Тэгээд ажлын хэсэг гараад энэ дээр тал талаасаа ярих ёстой. Нийтийн мэдээллийн тухай хууль өөрөө нийлээд Цахим гарын үсгийн тухай хууль, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын хууль гэсэн энэ 3 хуультай уялдаж байж нөгөө Монгол Улс цахим шилжилт рүү шилжих цахимын дөрвөн үндсэн суурь хууль болж байгаа. Энэ 4 хууль нэг нэгээрээ одоо амилахад их төвөгтэй. 10 жилийн өмнө тэр энэ нийтийн мэдээллийн хуулийн анхдагч хууль батлагдаж байсан гээд сая Сүхбаатар гишүүн хэлж байгаа юм. Энэ хуулийг дэмжиж цахим орчин, дэд бүтцийг холбосон нөгөө икс роут холболт хийгдсэн ийм эрх зүйн орчин бүрдээгүйгээс 10 жилийн хугацаанд энэ хууль бас хэрэгжихэд нэлээд төвөгтэй байсан. Одоо бол бид нар энэ 4 хуулийг бүхэлд нь энэ намартаа багтаагаад баталж чадсанаар энэ хуулиуд бүрэн тал талаасаа хэрэгжих ийм одоо үндсэн структур нь бүрдэж байгаа юм аа гэдгийг хэлье.

С.Бямбацогт: Баярлалаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье.

Цахимаар Мөнх-Оргил гишүүн, Дэлгэрсайхан гишүүн байна. Сүхбаатар гишүүн асуулт асууя.

Ж.Сүхбаатар: Түрүүний хэлдгээр энэ бол ардчиллыг хамгаалах, цаашдаа одоо хамгийн гол дархлаа бол иргэд байдаг аа. Иргэдэд мэдээлэл авах эрх чөлөө байж байж эрх зүйн соёл, эрх зүйт төрийн асуудал гарч ирдэг. Бид бол олон юм хэлдэг. Үндсэндээ энэ ардчилсан нийгмийн гол, хамгийн чухал юм нь болбол мэдээлэл л байдаг. Мэдээллийг нууцлах, мэдээллийг зүй бусаар ашиглах

явдалтай тэмцэнэ гэдэг бол бид ардчиллын төлөө тэмцэж байгаа л хэлбэр. Тэгэхээр энэ хуулийн утга агуулга бол ингээд маш чухал учраас тэр ажлын хэсэг байгуулаад хэлэлцүүлэг сайн хийх ёстой. Яаран сандран төрийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах гэж байгаа гэдэг утгаар хандаж болохгүй.

Энэ хуулийн зорилго нь бол төрд тавих иргэний хяналтыг бэхжүүлэх зорилготой хууль. Үүргээ биелүүлж байна уу, албан тушаалтан. Одоо энэ ковидын үед бол хамгийн чухал болж байна шүү дээ. Хүний эрх. Бид хүний эрхийг их ярьдаг боловч хүний эрхийн хамгаалалтын нэг хэсэг нь иргэдийн идэвхтэй, өөрийнх нь хамгаалалт буюу мэдээлэл авч ашиглах тэр эрхээр хэрэгждэг. Тэгэхээр энэ асуудал дээр бол, бид онцгой анхаарах ёстой учраас энэ чиглэлд нь үндэслэлгүй хязгаарлалт тавихаас бид сэргийлж энэ хуулиа гаргах ёстой. Нэг.

2 дахь юм нь бол, бид нар энэ Нийтийн мэдээллийн тухай хуулиар энэ төрд байгаа энэ шимэгчилсэн паразитладаг, мэдээллийг паразиталж ашиглаж амьдардаг тодорхой хэсэг байгаад байгаа юм. Тухайлбал миний одоо ойрын хүмүүсээс ч гэсэн улсын бүртгэл дээр байж байсан. Компанийнх нь мэдээллийг нь өөрчлөөд ингээд дээрэмдчихсэн, кино шиг. Одоо хүртэл тэр бодвол бүртгэлийн байгууллагадаа шигдэж суугаа л байх. Тэгэхээр тийм хулгайч паразитуудыг болбол юу одоо тэднийг одоо амьдрах хөрс нь болж байна вэ гэхээр энэ мэдээллийн хаалттай байдал. Ашиглах боломж. Жилээс жилд бид бол үүнийг сайжирч байгаа. Энэ нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглаад явж байгаа систем бол иргэдээс илүү дутуу мэдээлэл шаардахгүй гэж байгаа юм болбол түүнийг яг баталгаатай энэ хуульд хийж өгөх ёстой. Энэ хууль гарлаа, иргэдээс нэмэлт мэдээлэл шаардах боломж нь энэ хуулиар хязгаарлагдах ёстой. Наад зах нь.

3 дугаарт, мэдээлэл хүлээн авахад бид зүгээр одоо хуульд өөрөөр заагаагүй бол гэж биш, заавал нээлттэй байлгах мэдээллүүд гэж, хүний нөөцийн жишээлбэл ил тод байдал бол өнгөрсөн жилүүдэд муу явсан. Хэнийг ажилд авах гээд байгаа юм, ямар хүмүүс ажиллаад байгаа юм, ганцхан мөнгө л яриад байсан. Хамгийн хаалттай юм чинь бол хүний нөөцийн бодлого, менежментийн асуудал ил тод бус байна шүү. Тэр байгууллага салбарын хүний нөөцийн менежментийн, ил тод байдал хүмүүсийнх нь тэр байгаа албан тушаал хэн юм гэдэг тэр анкетын нэлээд хэсэг нь бол ил тод байх ёстой. Тэгж байж шаардлага тавина. Тэр одоо шахаа, намын шахаагаар гэнэ үү, хувь хүний шахаагаар гэнэ үү, бизнесменүүдийн шахаагаар гэнэ үү. Төрд орж байгаа хүмүүсийг ил болгох, гэрэл цохиулах юм болбол ил заавал байлгах нийтийн мэдээлэл. Тэр жагсаалтууд. Нууцалдаг юмаа бид бас энэ хуулийг дагалдуулаад төрийн нууцыг тэр хуулийн хүрээ хэмжээг бас хязгаарлах ёстой. Энэ хуулиас эхлээд бид хувь хүн ... /минут дуусав/

С.Бямбацогт: Мөнх-Оргил гишүүн саналаа хэлье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Би Сүхбаатар гишүүний саяын хэлсэн дээр нэгдүгээрт санал нэгтэй байгаагаа хэлээд, өөрөөр хэлбэл энэ бол зүгээр төрийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах тухай асуудал биш шүү. Энэ бол үндсэндээ Монгол Улсад цаашид ардчилал дарангуйлалгүй нийгэм тогтох, хөрс суурь нь бэхжих үү, үгүй юу гэдэг дээр л ярьж байгаа чухал асуудал шүү гэдгийг хэлэхийн ялдамд 2 санаа хэлэх гэсэн юм аа. Хуулийн одоо мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хэрэгжилтийг бид нар их сайн дүгнэж үзмээр байгаа юм аа. 10-аад жилийн өмнө хууль батлагдаад л одоо яг Нямбаатар сайдын ярьж байгаа шиг ийм үр дүн гарна гээд бид нар хүлээгээд л хуулиа баталсан. Хэрэгжилт

бол наанатай цаанатай, нэмэхтэй хасахтай байсан. Үүнийг дүгнэж үзмээр байгаа юм. Тэгээд гол юм миний бодлоор шүү. Би буруу бодож байж магадгүй. Гол юм бол энэ мэдээллийн эрх чөлөөний хуульд хэрэгжилтийг сааруулсан юм бол энэ Төрийн нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль. Ялангуяа Төрийн нууцын тухай хууль болон Байгууллагын нууцын хуулиуд, энэ мэдээллийн эрх чөлөөний хуулийн хэрэгжилтийг таг гацаасан. Яагаад вэ? Яагаад гэвэл Төрийн нууцын хуульд бүр хэрэгтэй хэрэггүй бүр өчнөөн юм оруулчихдаг. Интернет дээр ил дэл сул байж байгаа, зүгээр сансрын хиймэл дагуулаас аваад одоо интернет гүүгл ойсоор хүртэл харагдаж байгаа юмнуудыг хүртэл ингээд л бүр томоос нь авахуулаад жижиг хүртэл бүгдийг нь нууцалчихсан. Төрийн нууц гээд нэг.

2-т, байгууллага болгон юуг нууцлахаа өөрөө шийддэг учраас байгууллага ерөөсөө бүх асуудлаа нууцалчихдаг. Түрүүн Сайнзориг хэлээд байна л даа. Бүх юмаа нууцалчихсан юм чинь байгууллагын нууц болчихсон юм чинь. Тэр мэдээллийн эрх чөлөөний хууль ямар ч нэмэргүй болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхлээр энэ хоёр хуулиа хувь хүний нууцын хувьд орж ирж байгаа юм байна. Тэр Дэлгэрсайхан гишүүн маш чухал асуудлууд хэлж байна. Тэгээд энэ 3 хуулиа бид нар янзлахгүйгээр энэ мэдээллийн эрх чөлөө гэж нэрлэнэ үү. Нийтийн эрх нийтийн мэдээллийн тухай хууль гэж нэрлэсэн үү. Хаалттай, нээлттэй, хязгаарлалттай гэж нэрлэнэ үү. Энэ хэрэгжилт бүтэхгүй ээ. Тийм учраас энэ хуулиа хэлэлцээд явъя.

Засгийн газар нэн яаралтай энэ Төрийн нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хуулийг оруулж ир ээ. Оруулж ирэхгүй бол гишүүд санаачлаад үүнтэй хамт батлуулах хэрэгтэй. Тэгж байж энэ хэрэгжилт хангагдана аа.

Нэршлийн хувьд энэ Төрийн мэдээллийн тухай хууль гэж нэрлэх нь зөв үү, буруу юу? Би Учрал гишүүний яриад байгааг бодоод л сууж байна. Бас нэр нь жоохон зохимжгүй санагдаад байгаа юм аа. Ерөнхий гол санаа, агуулга бол төрийн болон төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын мэдээлэл ил тод байх тухай л агуулга ярьж байгаа шүү дээ бид нар. Тийм ээ, тэгэхээр төрийн мэдээлэл ил тод байх, төрийн мэдээллийг чөлөөтэй олж авах эрхийн тухай л асуудал. Бид нар энд ярьж байгаа байхгүй юу. Түүнээс биш нийтийн мэдээлэл гэдэг чинь одоо паблик информэйшн гэдэг чинь арай жоохон өөр ... /минут дуусав/

С.Бямбацогт: Баярлалаа. Мөнх-Оргил гишүүн бас үг хэллээ. Энхбаяр гишүүн үгээ хэлье.

Б.Энхбаяр: Баярлалаа. Би сая яг Мөнх-Оргил гишүүний хэлснийг бас үргэлжлүүлж давтаж хэлэх гэж байгаа юм. Энэ хуулийг бол Төрийн болон албаны нууцын тухай хуультай хамт шийдэхгүйгээр хэрэгжихгүй. Сая яг хэлсэн энэ албаны нууцын хуулийг төрийн байгууллагын дарга нар өөрсдөө тогтоодог. Энэ хуулийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан дээр юу гэж гарч ирээд байна вэ гэхээр ерөөсөө энэ төрийн байгууллагууд мэдээллээ өгөхөө больчихсон. Яагаад. Албаны нууц. Ерөөсөө байгууллагын дарга үзэмжээрээ бүх мэдээллээ албаны нууц гээд өгдөггүй, хаалттай болгочихсон. Энэ одоо над дээр хүртэл гарсан. Улсын Их Хурлын гишүүн чинь хяналт шалгалтынхаа хүрээнд асуулга болон асуулт тавих хэрэгтэй юм байна лээ. Бичгээр. Асуултыг 14 хоногийн дотор ямар ч сайд бичгээр өгөх үүрэгтэй юм байна лээ. Тэгээд 1 сайдаас асуулт тавьсан чинь надад албаны нууцын тамгатай асуултын хариу өгчхөж байгаа байхгүй юу. Тэгээд би нөгөө хариултаасаа мэдээлэл аваад ярих гэхээр би албаны нууц задруулсан гээд

шоронд орчих гээд байдаг. Эрүүгийн хуулиар. Түүнд нь ерөөсөө нууцлаад байгаа юм юу ч байхгүй. Хэдэн машинтай юм. Тэдний компани, төрийн өмчит компани. Ажилтан нь ямар цалин урамшуулал авч байгаа гэдэг ердийн мэдээлэл өгсөн чинь албыг нууц дараад өгчхөж байгаа байхгүй юу. Тэгээд би энэ хууль, албаны нууцын хууль бол ерөөсөө огт болохгүй, бүх юмыг хаасан, тэгээд зөрчвөл эрүүгийн хариуцлагатай шоронд орно. 5 жилээр шууд. Ийм хуулийн өндөр хариуцлагатай. Тэгээд нэг байгууллагын даргын хуудсан үзэмжээрээ нэг тамга дарж нуусан цалингийн мэдээллийг ярьсныхаа төлөө 5 жил шоронд орох юм уу? Ийм хаалттай систем бол байж таарахгүй.

2 дугаарт, энэ нийтийн мэдээллийн хуулийн 9.6, 9 дүгээр зүйл ер нь. 13 дугаар зүйлд байгаа энэ хязгаарлалттай мэдээлэл гэдгийг нэлээн сайн хэлэлцүүлгийн явцад авч үзэхгүй бол энэ дотор жишээлбэл ийм мэдээллүүд байгаа байхгүй юу. Төрийн хяналт шалгалтын явцад цуглуулсан мэдээллийг хязгаарлалттай мэдээлэл гээд. Тэгээд үүнийг зөвхөн мэдээлэл авах зорилгоо танилцуулж байж, бүх хаяг юмаа өгч байж, нөгөө хяналт шалгалт хийсэн, төрийн байгууллагын бичгээр гаргасан зөвшөөрлийг үндэслэж байж ил болгоно. Энэ бол болохгүй. Төрийн хяналт шалгалтын байгууллага чинь бүх төрийн байгууллага. Энэ аудитынхан хяналт, мэргэжлийн хяналтын шалгалтын мэдээлэл бол ил байх ёстой байхгүй юу. Харин. Энд ч тэр мэргэжлийн хяналтын даргаас нь зөвшөөрөл авч байж мэдээллийг нь ил болгодог ийм систем бол байж болохгүй. Тийм учраас энэ дээр бол онцгой анхаарах ёстой.

2 дугаарт, энэ бизнесийн гэрээнд зааснаар задруулах нь бизнесийн нууцыг зөрчиж болзошгүй мэдээллийг бас оруулчихсан байгаад байгаа юм. Үүнийг бас жоохон учиртай үзмээр байна. Төр өөрөө төрийн өмчит компаниараа дамжуулаад иргэний буюу хувийн эрх зүйн харилцаанд бас ордог. Төрийн өмчит компаниуд хувийн эрх зүйн хэлцлүүд хийгддэг ... /минут дуусав/

С.Бямбацогт: Алтанхуяг гишүүн саналаа хэлье.

Н.Алтанхуяг: Одоо дандаа бас муушаагаад яах вэ, сайшаая даа. Ингээд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль орж ирж байна. Нийтийн мэдээллийн тухай гээд. Энэ болбол би их тулгуур хууль гэж үзэж байгаа. Яг л энэ саяын Сүхбаатар гишүүн, Энхбаяр гишүүнтэй би санал нэг байгаа. Тэр ардчилал, ардчилал элдвийн юм яриад байна. Үүнийг чинь хэрэгжүүлдэг механизм нь энэ 2 гол хууль байна. Сая Хүний эрхийн Үндэсний комиссын илтгэл орж ирэхэд би бас Үндсэн хуулиараа манай иргэдэд олгогдсон 18 эрх байдаг юм байна лээ. Тэр эрхийн 5-ыг нь та нар нэг хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлээч ээ гэсний 2 нь бол өнөөдөр бас орж ирж байна аа. Нямбаатар сайд аа. Энд бас би баярлаж байна. Би ер нь ажлын хэсэгт нь орж ажиллая гэж бодож байна. Хэдүүлээ нэг жаахан тийм зөв юм гаргачихмаар байна.

Ер нь би бас энэ Сүхбаатар гишүүний хэлсэн нэг юмтай адилхан төрийн байгууллагад ажиллаж байгаа бүгдээрээ биш л дээ. Чааваас. Тэгэхдээ паразит. Паразит гэж одоо шимэгч хорхой л гэж хэлэх байх. Шимэгч хорхой нар их байна. Тэр бүртгэлийн байгууллагын мэдээллийг ашигладаг. Өөрснөө, өөрсдийнхөө хамаарал бүхий компанид ашигтай шийдвэр гаргуулах гэж даргыг нь хүртэл сольж байсан. Ийм түүх бас бий л дээ. Тэгэхээр энэ дээр бид нар анхаармаар байна.

Энхбаяр гишүүний хэлж байгаа нэг юмтай санал нэг байна. Тэгээд 3 ангилаад байна шүү дээ. Нээлттэй, хязгаарлагдмал, хаалттай гээд. Тэгээд би энэ

дотор нэг ингэж л хууль завхардаг гэж би нэг юм хэлэх гээд байна. Та нар 10.1-ийг хар даа. Би одоо концепц хэлж байна шүү. 10.1 дээр ингээд хаалттай мэдээлэл гэдэг дотор 10.1.3-т хуульд заасан бусад мэдээллийг хэлнэ ээ гэж байгаа юм. Ингээд л нэг хууль гаргаад л, түүн дотор ингээд л нэг юм хийгээд л оруулаад л, ингээд л эргээд харсан чинь бид нарын нөгөө нээлттэй байдаг хууль чинь хаалттай болоод хувирч байна. Тэгэхээр би концепц ярьж байна шүү, би сайн мэдэхгүй юм чинь та нар хэлээрэй. Ийм заалтыг авч хаямаар байна. Хувь хүний нууц энэ олон нийтийн, нийтийн мэдээллийн тухай хууль дээр 2 үндсэн гол хууль гэж үзээд энэ дээр л оруулж ирж заамаар байна. Бусад хуулиудад оруулчхаар л нэг өдөр орчихсон. Бид нар тэгээд мэддэггүй, хэрэлдээд сууж байдаг байхгүй юу. Үгүй ээ, хэзээ хаана ямар хуулиар орчихсон юм гэхээр салбар хуулиар орчихсон байхгүй юу. Тэгэхээр энэ болбол хүний эрхтэй холбоотой Үндсэн хуулиар олгогдсон эрхтэй холбоотой хууль учраас Нямбаатар сайд аа, энэ хоёр хууль руу л юмаа хиймээр байна. Ийм цоорхой өгмөөргүй байна.

Тэгээд би ажлын хэсэгт орж ажиллая, баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Дэлгэрсайхан гишүүн үгээ хэлье.

Б.Дэлгэрсайхан: Баярлалаа. Би энэ Сүхбаатар гишүүнтэй бас санал нэг байна л даа. Зүгээр урьд нь ийм юм зөндөө гарч ирсэн. Одоо гарч байгаа эсэхийг бол мэдэхгүй байна. Зүгээр урьд нь бол бүртгэл дээр энэ мэдээллийг хольж сольдог ийм их гарч байсан. Тэгээд ялангуяа энэ компаниудын бүртгэлийн мэдээллийг хольж, солиод гэмт хэргийн нотлох баримт болгож ашиглаж байсан явдал маш их гарч байсан. Одоо эрх биш нэг гайгүй болсон байлгүй гэж бодож байна. Тэгээд энэ бас өөрчлөгдсөн үү, үгүй юу.

Дээрээс нь энэ хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт гүйцэтгэх ажлын мэдээлэл чинь одоо уул нь бол байгууллагынхаа хуулиар ч тэр хаалттай баймаар юм. Сүүлийн үед ийм мэдээллийг энэ хэвлэл мэдээллийнхэн хамаагүй их гаргадаг болчихлоо. Тэгээд үүнд өгдөг, ийм тусдаа мэдээлэл өгдөг хууль хяналтын байгууллагын ажилтан байна л даа. Дотроосоо мэдээлэл өгдөг. Тэгээд үүн дээрээ ямар арга хэмжээ авах юм. Энэ чинь одоо тэгээд нэг зүгээр нэг сахилгын ч юм уу арга хэмжээ аваад ингээд өнгөрчихдөг. Тэгээд нөгөө хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт нь дөнгөж эхэлж байтал шууд хэвлэлээр цацаад тийм муухай юм гарч байсан. Урьд нь та бүгд санаж байгаа байх. Отгонбаяр гишүүн дээр энэ элчин сайд байгаа. Нэг о мөрдөн байцаагч билүү төлөөлөгч гараад хэвлэлийн мэдээлэл хийхдээ орон тоо алдаж хэлээд л. Тэгээд л хүнийг орвонгоор нь тэр айлын амьдрал ахуйг эргүүлсэн шүү дээ. Тэгээд ийм мэдээлэл энэ тэрийн төлөө ямар хариуцлага хүлээх юм бэ. Энэ санкц ерөөсөө байхгүй юм байна шүү дээ, энэ чинь.

Тийм учраас энэ төрийн болон албаны нууц энэ Энхбаяр гишүүний ярьж байгаа ч гэсэн бас үнэн. Ялангуяа төрийн өмчийн компаниуд бол бүгд хаалттай. Нэг мэдээлэл авъя гэхээр, бүх юм нь нууц үйл ажиллагаа явуулж байгаа, алдагдалтай ажиллаж байгаа компаниудын мэдээлэл бол бүр нууц. Хулгай хийж байгаагаа нуудаг юм байна л гэж одоо бодоод л өнгөрдөг. Тийм учраас энэ мэтийгээ тэр нууцлалаас нь энэ хасдаг юм уу, эсвэл заавал өгөх ёстой гэдэг юм уу тэр байгууллагын албаны нууц гэдгийг юун дээр дарах юм, юун дээр дарахгүй байх юм энэ тэр гэдгээ бас энэ хуульдаа зааж өгөх хэрэгтэй байх аа. Тэгэхгүй бол төртэй холбогдсон бүх л зүйл нууц болоод байдаг. Тэгээд дээрээс нь хувь болоод компанийн хүний мэдээллийг хольж сольдог юмаа л одоо энэ хуульдаа нэлээн сайн зааж өгөхгүй бол болохгүй байх аа гэж бодож байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж гишүүд үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна.

Бүртгэлийн санал хураалт эхлээд явуулчихъя. Гишүүд ай падаараа санал өгнө. Тийм ээ.

Бүртгэлийн санал хураалт.

Ганбат гишүүн, Пүрэвдорж гишүүн, Раднаасэд гишүүн, Сэргэлэн гишүүн, Учрал гишүүн, Энх-Амгалан гишүүн, Амарсайхан гишүүд ирцдээ орохыг хүсэж байна аа. Гишүүдийг ирцдээ орохыг хүсэж байна.

Санал хураалт явуулчихъя.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 18 гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 66,7 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх талаарх хэлэлцүүлэг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Их Хурлын гишүүн Мөнхбаатар гишүүн танилцуулчихъя.